



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/322

Чингис хот

Коронавируст халдвар цар тахалтай тэмцэх,  
урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй  
арга хэмжээг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын 2020 оны 62, 64, 102 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 25, 07 дугаар сарын 09-ний өдрийн 26 дугаар хурлын шийдвэрүүд, аймгийн Онцгой комиссын №27 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусын халдвар /КОВИД-19/ цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд сунгасугай.

2. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан зөвлөмж шаардлагыг хангасан хүүхдийн тоглоомын газар, баар, шашин, соёл урлаг, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг халдвар хамгааллын горимыг чанд мөрдүүлэн ажиллуулах, түүнд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/-т үүрэг болгосугай.

3. Коронавируст халдвар цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг эрчимжүүлэх, иргэд олон нийтэд сурталчилах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, халдвар, хамгааллын дэглэм, зөвлөмжийг мөрдүүлэх, төрийн алба хаагчдын сахилга хариуцлагыг нэмэгдүүлэхийг Эрүүл мэндийн газар /Ц.Гэрэлмаа/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА